

“ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Нэг. Судалгааны ажлын үндэслэл, зорилго

1.1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтад “шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах” гэж заасныг үндэслэн Комиссоос 2024, 2025 онд явуулж буй “Хүний эрх ба Технологи” олон нийтийн хяналт шалгалтын хүрээнд энэхүү судалгааны ажлыг явуулна.

1.2. Судалгаа нь хиймэл оюун ухаанд суурилсан технологийг төрийн үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаанд ашиглах, хүний оролцоогүйгээр хүний хувийн мэдээллийг боловсруулах, их өгөгдлийг үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой Монгол Улсын бодлого, эрх зүйн зохицуулалтын хүний эрхийн зарчимд нийсэн байдлыг үнэлж, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сайжруулах санал гаргах зорилготой.

Хоёр. Судлах асуудал

2.1. Судалгааны баг дараах асуудлыг тогтооно. Үүнд:

2.1.1. Цахим хөгжлийн багц хууль, Инновацын тухай хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль, "Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам", "Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам" зэрэг хиймэл оюун ухаан ашиглах, хөгжүүлэх бодлого, эрх зүйн зохицуулалтыг хүний эрхийн зарчмын үүднээс үнэлэх;

2.1.2. UNESCO: Хиймэл оюун ухааны ёс зүйн тухай зөвлөмж, USA: Government Ownership and Oversight of Data in AI, National Institute Strategy of Standards and Technology: AI risk assessment work, EU: Proposal for the AI, UK: National AI Strategy зэрэг хиймэл оюун ухааны хүний эрхийн эрсдэлийг зохицуулах НҮБ-ын болон бусад улс орны бодлого, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;

2.1.3. Хиймэл оюун ухаанд суурилсан технологийг төр, хувийн хэвшилд ашиглахад боловсруулсан мэдээлэл, үйлдэл, алгоритмын ил тод байдал, мэдээлэх авах эрхийг хангаж буй байдал, энэ талаарх эрх зүйн зохицуулалтын хангалттай, үр дүнтэй эсэхэд дүн шинжилгээ хийх;

2.1.4. Хиймэл оюун ухаанд суурилсан технологийн хүний эрхийн эрсдэлийг тооцох, эрсдэлийг бууруулах талаар Монгол Улсын нөхцөлд байдалд тохирсон, үр дүнтэй эрх зүйн зохицуулалтын санал боловсруулах;

Гурав. Судалгааны аргачлал

3.1. Судалгааны ажлыг дараах аргачлалаар явуулна. Үүнд:

3.1.1. Эрх зүйн дүн шинжилгээ, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийх;

3.1.2. Асуудалд холбогдох судалгааны тайлан, хоёрдогч эх сурвалжийг судлах, харьцуулах;

3.1.3. Хамаарах асуудлаар төрийн үйлчилгээний болон бизнесийн салбарын оролцогч нартай уулзалт, ярилцлага хийх;

3.1.4. Олон нийтээс мэдээлэл, баримт авч, дүн шинжилгээ хийх;

3.2. Судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг эрх бүхий байгууллагуудаас гаргуулж авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад Комисс дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Судалгааны ажлын үр дүн, зохион байгуулалт

4.1. Судалгааны баг нь ажлын явц, урьдчилсан үр дүнгийн талаар Комисст ажил эхэлснээс хойш нэг сарын дараа уулзалт зохион байгуулж тайлагнана. Бусад үед Комиссын хариуцсан ажилтантай байнгын харилцаа холбоотой байж, мэдээлэл солилцож ажиллана.

4.2. Гэрээнд заасан хугацаанд энэ ажлын даалгаврын Хоёрт тусгасан асуудлуудыг бүрэн дүгнэсэн, агуулга, хэлбэрийн хувьд мэргэжлийн шаардлага хангасан дүгнэлт, санал бүхий тайланг Комисст хүлээлгэн өгнө.

4.3. Шаардлагатай гэж үзвэл судалгааны урьдчилсан үр дүн, санал, дүгнэлтийн төсөлд санал авах уулзалтыг зохион байгуулж, тайланд тусгана.

4.4. Судалгааны ажлын тайланг бусад нэмэлт материалын хамт захиалагчид хүлээлгэн өгч, гэрээний хэрэгжилтийг Комисс дүгнэснээр ажлыг дуусгавар болсонд тооцно.

4.5. Судалгааны ажлын явцад гүйцэтгэх шаардлагатай болсон бусад ажил, үйл ажиллагааг Комисстой зөвшилцөн явуулж болно.

Тав. Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа, төсөв

1.1. Ажлыг хоёр сарын хугацаанд гүйцэтгэх ба төсөв нь 13,000,000 (Арван гурван сая) төгрөг байна.

Зургаа. Судалгааны багт тавигдах шаардлага

6.1. Судлаачид дараах шаардлагыг хангасан байна:

6.1.1. Судалгааны ажлыг гүйцэтгэх судлаач нь эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх; Магистр түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байвал давуу талтай гэж тооцогдоно.

6.1.2. Хууль зүйн бодлогын болон хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын судалгааны ажил явуулах ур чадвар, туршлагатай байх; Холбогдох чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэж байсан нь давуу тал болно.

6.1.3. Баримт бичиг боловсруулах, тайлагнах, амаар болон бичгээр илтгэх, холбогдох хэрэглээний программыг ашиглах, багаар ажиллах чадвартай байх.

-----oO-----